

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОО-2024/03/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2024 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn

Аудитор: Б.Оюунхэрлэн

Утас: 7058-4207, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 7058-4207, Цахим хаяг: odkhuub@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.03.21 № 303

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ Т
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ОТГОНБААТАР ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор материаллаг шинж чанартай 1,704.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Сөрөг дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тайланд тусгагдсан татварын өр төлбөрийн дүн цахим татварын систем дэх татварын тооцооллын эцсийн үлдэгдлийн дүнгээс 897.8 сая төгрөгийн илүү байна. Мөн татварын албатай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тайлант хугацаанд тендерээр худалдан авсан ижил нэр төрлийн материалыг өөр компаниас босго үнэ давсан үнийн дүнгээр 4 иргэнээс 85.2 сая төгрөгийн, 10 компаниас 156.3 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "босго үнэ" гэж бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгөөс хамааруулан тендер шалгаруулалтыг энэ хуульд заасан журмын дагуу явуулахад баримтлах үнийн дээд, эсхүл доод хязгаарыг", 8.2-д "Энэ

011021168

хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 3.1-д “Худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд нийцүүлэн захиалагч төлөвлөгөөг хуулийн 48 дугаар зүйл болон энэ журамд заасны дагуу санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан даруйд боловсруулна” гэснийг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Тендерийн болон тендерийн бус 538.1 сая төгрөгийн худалдан авалтад ашиг сонирхлын зөрчилтэй болон гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрч, хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн.
4. Томилох эрх бүхий албан тушаалтны томилсон, үнэлсэн албан томилолтын үнэмлэхгүй 13,780.7 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрчим хүчний яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтад хийсэн шалгалтын үр дүнд тулгуурлан гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг 48 хувь буюу хангалтгүй гэж үнэлсэн байна.

Аудитын гол асуудал

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь Чойбалсангийн дулаан, цахилгааны станцын суурилагдсан хүчин чадлыг 50мвт-ийн шинээр станц өргөтгөх төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын хөгжлийн банкнаас авсан зээлийн 107,986.0 сая төгрөг, хуримтлагдсан хүүгийн 1,278.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөн “Дорнодын ДЦС-ын зуух, турбин, хими ус бэлтгэл, цахилгаан тоноглол, дулааны автоматикийн тоноглолуудыг солих”-оор ХБНГУ-ын Сэргээн Босголтын Банк (KfW)-наас, “Чойбалсан хотын цахилгаан, дулааны шугам сүлжээний алдагдал бууруулах”, “Сүхбаатар аймгийн ЦДАШ болон Дэд станцыг шинэчлэх”-ээр Дэлхийн банкны хөрөнгөөр хэрэгжүүлэхээр Засгийн газраар дамжуулан авсан 6,284.4 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд Засгийн газрын 2023 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 3.1.7 дахь “төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй байх” гэсэн шаардлагыг хангаагүй хүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 08 дугаар тогтоолоор томилсон байна.

Удирдлага болон Засаглал эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант үе	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.00	ХӨРӨНГӨ		
1.10	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	489,022,538.74	247,398,223.51
1.1.2	Дансны авлага	1,271,712,664.67	1,543,372,328.37
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,215,372,232.17	1,391,527,240.70
1.1.4	Бусад авлага	295,371,884.39	108,832,319.35
1.1.6	Бараа материал	2,455,542,569.62	3,199,738,852.87
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	11,393,150,383.85	31,913,623.47
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	185,552,000.00	216,819,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	17,305,724,273.44	6,739,601,588.27
1.20	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	108,493,427,400.37	227,366,318,025.82
1.2.2	Биет бус хөрөнгө	18,388,493,757.67	19,080,918,248.69
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	126,881,921,158.04	246,447,236,274.51
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	144,187,645,431.48	253,186,837,862.78
2.00	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.10	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	6,162,220,926.10	9,311,695,416.94
2.1.1.2	Цалингийн өглөг	198,336,278.52	16,584,020.13
2.1.1.3	Татварын өр	1,204,053,369.27	2,196,840,146.18
2.1.1.4	НДШ-ийн өглөг	178,780,306.33	107,180,635.19
2.1.1.6	Хүүний өглөг	472,572,686.75	1,278,168,317.53
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	400,165,476.39	603,391,874.19
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,616,129,043.36	13,513,860,410.16
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	41,951,266,173.51	114,379,788,915.15
2.1.2.5	Хойшлогдсон орлого	15,514,621,137.21	42,308,425,697.44
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	57,465,887,310.72	156,688,214,612.59
2.20	Өр төлбөрийн нийт дүн	66,082,016,354.08	170,202,075,022.75
2.30	Эздийн өмч		
2.3.1	᠒᠕: -төрийн	51,370,219,512.43	51,590,219,512.43
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,132,551,322.91	11,111,700,363.84
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	18,545,030,500.68	18,325,030,500.68
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-2,942,172,258.62	1,957,812,463.08
2.3.11	Эздийн өмчийн дүн	78,105,629,077.40	82,984,762,840.03
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	144,187,645,431.48	253,186,837,862.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 -р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	50,558,145,931.50	66,502,657,078.86
2	Борлуулалтын өртөг	38,589,949,108.65	44,155,853,157.11
3	Нийт ашиг/алдагдал/	11,968,196,822.85	22,346,803,921.75
4	Түрээсийн орлого	50,997,054.57	32,057,090.84
5	Хүүний орлого	-	11,081,897.93
8	Бусад орлого	861,359,253.85	1,688,188,824.65
9	Борлуулалт, маркетингийн зардал	10,396,218,174.78	12,240,707,060.38
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,331,836,500.58	2,954,848,650.34
11	Санхүүгийн зардал	73,690,521.15	67,771,125.12
12	Бусад зардал	2,157,834,129.21	3,814,652,677.63
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-3,391,676,046.81	390,902,536.38
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-5,470,702,241.26	5,391,054,758.08
19	Орлогын татварын зардал		511,913,563.20
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-5,470,702,241.26	4,879,141,194.88
22	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	-5,470,702,241.26	4,879,141,194.88
24	Орлогын нийт дүн	-5,470,702,241.26	4,879,141,194.88
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12 сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1.	Мөнгөн орлогын дүн (+)	55,753,637,501.02	73,380,881,451.97
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	54,601,641,117.15	71,704,405,091.13
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	88,342,949.00	81,517,716.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,063,653,434.87	1,594,958,644.84
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	47,962,804,957.67	65,335,147,533.05
1.2.1	Ажилчдад төлсөн	14,114,529,750.83	18,480,331,251.27
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,343,026,906.12	5,529,088,533.24
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	11,203,319,107.55	16,067,957,842.90
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	35,751,283.36	36,745,415.73
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,135,584,590.75	14,009,336,116.36
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	2,063,948,207.95	2,958,171,936.20
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,472,450,768.90	5,705,515,254.11
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	179,723,903.75	189,931,832.40
1.2.9	Бусад мөнгөн зарлага	414,470,438.46	2,358,069,350.84
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,790,832,543.35	8,045,733,918.92
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,450,000.00	25,444,762.32
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	5,450,000.00	14,375,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	11,069,762.32
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	19,434,327,270.76	81,126,732,734.93
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	7,424,187,236.05	4,930,929,049.51
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	42,086,363.64	737,571,946.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө	11,968,053,671.07	75,458,231,739.42
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-19,428,877,270.76	-81,101,287,972.61
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,968,053,671.07	74,373,557,534.42
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	11,968,053,671.07	74,373,557,534.42
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	503,493,370.39	1,559,627,795.96
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	135,796,074.00	1,534,923,679.80
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	23,504,728.64	24,696,683.91
3.2.4	Төлсөн ногдол ашиг	344,192,567.75	7,432.25
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний	11,464,560,300.68	72,813,929,738.46
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-173,484,426.73	-241,624,315.23
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	662,506,965.47	489,022,538.74
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	489,022,538.74	247,398,223.51

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	50,825,627,452.43	11,245,314,869.70	18,844,022,560.00	2,759,959,003.60	83,674,923,885.73
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					0.00
3	Залруулсан үлдэгдэл					0.00
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-5,470,702,241.26	-3,981,774,159.49
6	Өмчид гарсан өөрчлөлт	544,592,060.00		-298,992,059.32		0.00
7	Зарласан ногдол ашиг				-344,192,567.75	-344,192,567.75
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-112,763,546.79		112,763,546.79	0.00
9	2022 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	51,370,219,512.43	11,132,551,322.91	18,545,030,500.68	-2,942,172,258.62	78,105,629,077.40
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					0.00
11	Залруулсан үлдэгдэл					0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				4,879,141,194.88	4,879,141,194.88
14	Өмчид гарсан өөрчлөлт	220,000,000.00		-220,000,000.00		0.00
15	Зарласан ногдол ашиг				-7,432.25	-7,432.25
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-20,850,959.07		20,850,959.07	0.00
17	2023 оны 12 дугаар сарын 31 үлдэгдэл	51,590,219,512.43	11,111,700,363.84	18,325,030,500.68	1,957,812,463.08	82,984,762,840.03

**“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан**

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт		Хэмжих	2022	2023		өөрчлөлт	
			нэгж		төл	гүйц	дүн	хувиар
1	ЦЭХ боловсруулалт		сая. кВтц	242.69	241.97	248.85	6.88	2.8%
2	Дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний зарцуулалт	хувиар	хувь	13.22%	13.66%	13.18%	-0.48%	-3.5%
		биет	сая. кВтц	32.07	33.05	32.81	(0.24)	-0.7%
3	Нийт түгээх ЦЭХ		сая. кВтц	278.1	281	296	15.00	5.3%
	Үүнээс:	Өөрийн түгээх ЦЭХ	сая. кВтц	210.6	208.9	216	7.10	3.4%
		ХАЦЭХ-ДУТ	сая. кВтц	67.3	71.8	79.7	7.90	11.0%
		Импортын ЦЭХ	сая. кВтц	0.177	0.223	0.237	0.014	6.3%
4	Түгээх ДЭХ		мян.Гкал	326	320.3	330.7	10.40	3.2%
5	ЦЭХ-ний түгээлтийн алд	хувиар	хувь	7.96%	7.60%	9.00%	1.40%	18.4%
		биет	сая. кВтц	14.8	11.8	14.77	2.97	25.2%
6	Борлуулах цахилгаан эрчим хүч		сая. кВтц	263.4	269.2	281.2	12.00	4.5%
7	Нийт орлого		сая.төг	52,167.50	66,187.70	68,234.05	2,046.35	3.1%
	Үүнээс:	Үйл ажиллагааны орлого	сая.төг	50,558.10	65,558.90	66,502.70	943.80	1.4%
		Үйл ажиллагааны бусад орлого	сая.төг	1,483.00	628.8	971.85	343.05	54.6%
			50 мВт ТХН-ийн орлого	сая.төг	126.3	-	759.5	759.50
8	Нийт зардал		сая.төг	57,638.20	62,556.60	63,235.08	678.48	1.1%
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	41,778.40	51,068.80	51,064.50	(4.30)	0.0%
		Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг	сая.төг	10,629.50	10,118.50	10,765.90	647.40	6.4%
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	4,613.30	1,369.30	769.08	(600.22)	-43.8%
		50 мВт ТХН-ийн зардал	сая.төг	617.1	-	635.6	635.60	0.0%
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал		сая.төг	6,469.80	6,565.60	6,485.00	(80.60)	-1.2%
9	Татвар төлөхийн өмнөх ашиг, / алдагдал/		сая.төг	-5,470.70	3,631.00	5,391.10	1,760.10	48.5%
10	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал /		сая.төг	-5,470.70	3,268	4,879.10	1,611.10	49.3%
11	БО-ын 1 төгрөгт ногдох зардал		төг	0.905	1.058	1.079	0.021	2.0%
12	Нийт авлага		сая.төг	14,175.60	41,976.60	41,427.62	(548.98)	-1.3%
	Үүнээс:	ЦЭХ-ний	сая.төг	1,271.70	1,628.30	1,543.40	(84.90)	-5.2%
		Бусад	сая.төг	12,903.90	40,348.30	39,884.22	(464.08)	-1.2%
13	Нийт өр төлбөр		сая.төг	50,567.40	131,395.70	127,893.60	(3,502.10)	-2.7%
	Үүнээс:	УХӨТ	сая.төг	41,951.30	125,432.10	114,379.80	(11,052.30)	-8.8%
		БХӨТ	сая.төг	8,616.10	5,963.60	13,513.90	7,550.30	126.6%
14	Нийт ажилтнуудын тоо		тоо	619	620	615	(5.00)	-0.8%
15	Нийт цалингийн сан		сая.төг	15,901.45	20,015.29	19,630.06	(385.23)	-1.9%
16	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ		сая.төг	5,938.15	5,677.70	5,611.48	(66.22)	-1.2%

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар 38.5 сая төгрөгийн 1 алдаа илрүүлж, залруулсан. Чойбалсангийн ДЦС-ын 50МВт-ын өргөтгөлийн гүйцэтгэлээрх санхүүжилтийг 2 өөр дансанд хуримтлуулж бүртгэсэн байна. Хөгжлийн банкны гүйцэтгэлийн санхүүжилтийг Дуусаагүй барилга дансанд, Улсын төсвөөс олгосон гүйцэтгэлийн санхүүжилтийг Урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэсэн. ААНБ-ийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааварт "Урьдчилж төлсөн зардал/тооцоо дансанд тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг (даатгал, түрээс г.м) санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зарлагыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ. Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна. Дуусаагүй барилгад баригдаж буй барилгатай холбоотой гарсан шууд материал, шууд хөдөлмөр болон нэмэгдэл зардлуудын хуримтлагдсан дүнг бүртгэж, барьж эхэлсэн огноо, дуусгалтын хувь болон бусад мэдээллийг тодруулна" гэж заасан байна. Чойбалсангийн ДЦС-ын 50МВт-ын өргөтгөлийн гүйцэтгэлээрх санхүүжилт нь эх үүсвэрээс үл хамааран Дуусаагүй барилга дансанд хуримтлагдан бүртгэгдэнэ.

Аудитаар нийт 4,313.1 сая төгрөгийн 31 зөрчил¹ илэрснээс, 20.5 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 1,466.4 сая төгрөгийн 7 албан шаардлага, 1 хариуцлага тооцуулах албан шаардлага, 2,288.1 сая төгрөгийн 9 зөвлөмж өгч, худалдан авах ажиллагаатай холбоотой 538.1 сая төгрөгийн ашиг сонирхлын зөрчилтэй болон гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрснийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн ажиллалаа.

3.1 Төлбөрийн акт

1. Дулааны цахилгаан станц-3 ТӨХК-ийн 55 жилийн ойг тохиолдуулан спортын тэмцээнд оролцоход 2,916.2 мянган төгрөгийн томилолтын зардал гаргасан. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх “Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.6 дахь “сахилга баттай байх”, 4.1.3 дэх “үр ашигтай байх”, 4.2.6 дахь “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудыг зөрчсөн.
2. Албан хаагчдын хувийн хэрэглээнд зориулж 4,956.4 мянган төгрөгийн шатахуун олгосон. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” 6.2 дахь “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.” гэсэн заалтуудыг зөрчсөн.
3. Улаанбаатар хот руу ачаа тээвэрлэх зардалд 630.0 мянган төгрөг зарцуулсан нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Хэвлэлийн захиалгад 792.0 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.3 дэх “хэвлэлийн захиалгын төлбөр” гэснийг зөрчсөн.
5. Гүйцэтгэх захиралд сахилгын шийтгэлтэй байх хугацаанд 5,103.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гүйцэтгэх захиралтай 2022 оны 05 дугаар 26-ны өдөр байгуулсан “онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний 4.4-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн гүйцэтгэх захирлын сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй тохиолдолд сарын болон жилийн үр дүнгийн нэмэгдэл болон урамшуулал олгохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.
6. Зарим албан хаагчдын цалинг 23.8-аас 28.9 хувиар нэмэгдүүлж 880.7 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн албан хаагчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлсэн 2023.11.13-ны өдрийн 23 дугаар тогтоол, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-д “Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна”, 83.6-д “Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна” гэж заасныг зөрчсөн байна.

7. Худалдах, худалдан авах гэрээнд заасан хугацааг хэтрүүлж нийлүүлсэн 2 аж ахуйн нэгжийн алдангийг 1,866.6 сая төгрөгөөр дутуу тооцоолсон, гэрээнд заасан гэрээ сунгах нөхцөл бүрдээгүй болон гэрээ сунгах хүсэлт ирүүлээгүй байхад гэрээг сунгаж 3,360.4 мянган төгрөгийн алданги тооцоогүй 1 аж ахуйн нэгж байна. Энэ нь Худалдах, худалдан авах гэрээний 6.1.нийлүүлэгчийн буруугаас шалтгаалан гэрээний 2.1-т заасан хугацаанаас хоцорвол гэрээний үнийн дүнгийн 0.2 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөх ба; 7.1.давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно; 7.2.гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ; гэсэн заалтуудыг зөрчсөн тул 5,227.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын чиг үүргийг давхардуулан гүйцэтгүүлж, 971.1 мянган төгрөгийн зардал гаргасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2 дахь “чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
2. Тайлант оны төсөвт 2023 оны халаалтын улирлын хөнгөлөлтийг зөвхөн галлагаатай сууцанд амьдардаг албан хаагчид болон ахмад ажилчдад тус бүр 100.0 мянган төгрөг олгохоор нийт 27.1 сая төгрөг баталсан бөгөөд гүйцэтгэлээр бүх албан хаагчдад нийт 79.2 сая төгрөг олгосон. Мөн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй 74.5 сая төгрөгийн халаалтын улирлын хөнгөлөлтийг 2023 онд нөхөж олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” 43 дугаар зүйлийн 43.5 дахь “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
3. Санхүүгийн тайланд тусгагдсан татварын өр төлбөрүүдийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Татварын ерөнхий газраас авсан лавлагааны дүнгээс 897.8 сая төгрөгөөр зөрүүтэй буюу илүү илэрхийлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй өр төлбөр бодитоор оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
4. Бараа материал дансанд бүртгэлтэй малыг мах болгон бэлтгэхдээ махны бодит жинг гаргаж бараа материалд бүртгээгүй хариуцсан албан хаагчийн нэр дээр авлагаар бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

5. Худалдах, худалдан авах гэрээнд заасан гэрээ сунгах нөхцөл бүрдээгүй байхад гэрээг сунгаж, 297.4 сая төгрөгийн алданги тооцоогүй байна. Энэ нь Худалдах, худалдан авах гэрээний 6.1-д “нийлүүлэгчийн буруугаас шалтгаалан гэрээний 2.1-т заасан хугацаанаас хоцорвол гэрээний үнийн дүнгийн 0.2 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөх ба”, 7.1-д “давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно”, 7.2-д “гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас дотоод аудиторыг ТУЗ-ын дэргэд ажиллуулах зохицуулалт хийснийг хэрэгжүүлэхдээ Дотоод хяналтын албыг татан буулгаж, дотоод хяналтын ажилтныг чөлөөлж, 106.9 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь батлагдсан төсөвт байхгүй зардал гаргасан. Энэ Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэснийг зөрчсөн байна.
7. Тус байгууллагын төслийн ажлаар явсан Эрчим хүчний яамны холбогдох албан тушаалтнуудын гадаад албан томилолтын зардалд 13,780.7 мянган төгрөг олгосон байна. Энэ нь томилох эрх бүхий албан тушаалтны томилсон болон үнэлж хаасан томилолтын үнэмлэхээр нотлогдохгүй байна. Энэ нь ажил гүйлгээ тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Мөн Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.
8. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитаар Сөрөг дүгнэлт авсан учраас Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно. заасны дагуу хариуцлага тооцуулах албан шаардлагыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга О.Хуягцогт-д хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нөөцлөх шаардлагагүй бичиг хэргийн материал, сэлбэг хэрэгслийг их хэмжээгээр нөөцөлсөн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу их хэмжээгээр шаардлагагүй бараа материал нөөцлөхгүй, бараа материалыг үр ашиггүй удаан хугацаагаар хадгалахгүй байх.

2. Шагнал, урамшуулалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 12 гишүүнийг үндсэн цалингийн 20%-аар буюу 5,953.2 мянган төгрөгөөр шагнасан зардал тухайн жилийн төсөвт тусгагдаагүй бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмч хамгаалах зөвлөлийн журамд урамшуулал олгож болно гэж заасан ч бодит үр дүнд үндэслэж, төсвийг зохих ёсоор батлуулж урамшууллыг олгох.

3. Татварын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2022 онд 2,071.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд уг алдагдлыг харьяа татварын албаар баталгаажуулаагүй байна. Уг алдагдлыг баталгаажуулсан бол Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д “Харьяалах татварын албаар баталгаажуулсан ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг тухайн алдагдал гарсан татварын жилийн дараах дараалсан дөрвөн жил бүр албан татвар ногдуулах орлогын нийт дүнгийн 50 хувиар хязгаарлан хасаж тооцно” гэж заасны дагуу 2023 оны татвар ногдуулах орлогыг 2,071.0 сая төгрөгөөр бууруулах боломжтой байсан.

Өгсөн зөвлөмж: Татварын хууль тогтоомжийг судалж, татварын зардлыг багасгах боломж бололцоог хуулийн хүрээнд ашиглах

4. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдах, худалдан авах гэрээг сунгахдаа гэрээнд заасан гэрээг сунгах нөхцөлийг баримтлан ажиллаагүй, 33.9 сая төгрөгийн алданги тооцоогүй.

Өгсөн зөвлөмж: Цаашид худалдан авах ажиллагааны гэрээнд гэрээг сунгах нөхцөлийг тодорхой зааж өгөх, гэрээнд заагаагүй нөхцөлөөр гэрээг сунгахгүй байх, гэрээний үүргийг биелүүлээгүй тохиолдолд алдангийг үнэн зөв тооцож байх

5. Тендерийн баримт бичиг, архивтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тендер шалгаруулалт бүрийн хавтаст хэргийг бүрдүүлэхдээ нийлүүлэгч байгууллагаас ирсэн бичиг, Сангийн яамнаас ирсэн бичиг зэрэг хуульд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлээгүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална”, 49.2-д “Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу бүрдүүлж, иж бүрэн архивын нэгж болгох.

6. Хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дуусаагүй барилга дансанд 1,774.8 сая төгрөгийн нөөц бараа материалыг бүртгэсэн нь ААН-ын санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааварт “Дуусаагүй барилга гэсэн зүйл ангиар бүртгэсэн баригдаж буй барилгатай холбоотой гарсан шууд материал, шууд хөдөлмөр болон нэмэгдэл зардлуудын хуримтлагдсан дүн, барьж эхэлсэн огноо, дуусгалтын хувь болон бусад мэдээллийг тодруулна” гэсэнтэй нийцэхгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон Цагаан-Овоо сумын 0.4 кВ-ын ЦДАШ-ийг бүртгэхдээ НББОУС 20 "Засгийн газрын буцалтгүй тусламжийн бүртгэл" стандартын капиталын аргыг ашиглан бүртгэж эзний өмчийг 220.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бол Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг 50МВт шинэ станцаар өргөтгөх төслийн гүйцэтгэлийг орлогын аргаар бүртгэж байна. Энэ нь НББ-ийн бодлого, зарчмаа тууштай мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн зэрэгцүүлэгдэхүйц байдал алдагдсан, НББОУС 8.13-д "СТОУС-д ажил гүйлгээ, үйл явдлыг бүртгэхэд өөр бүртгэлийн бодлого хэрэглэх нь зохистой гэж үзсэнээс бусад үед аж ахуйн нэгж ижил төрлийн ажил гүйлгээ, үйл явдлыг бүртгэхэд нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тууштай сонгож мөрдөнө" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлого, зарчмыг тууштай мөрдөж ажиллах.

7. Дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт: Дотоод аудитын нэгжийг одоог хүртэл томилоогүй байгаа нь тус компанийн дүрмийн 2.3 дахь хэсэгт заасан “Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дотоод аудитын нэгж хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод аудитын нэгжийг томилох.

8. Хамтын гэрээтэй холбоотой

Илрүүлэлт: Тус компанийн захиргаа болон үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан Хамтын гэрээний 3.20-д Тус компанийн Эрчим хүчний тэргүүний ажилтан болон бусад салбарын тэргүүний ажилтанд сар бүр 15 000 /арван таван мянга/ төгрөгийн урамшуулал олгоно. /Компанийн ахмадууд болон групптэй хүмүүст хамаарна/, 5.2.Халаалтын улирлын хөнгөлөлтийг нийт ажилтанд нэг зуун мянган төгрөгөөр бодож олгоно. /Ахмадууд, үйлдвэрлэлийн осол, мэргэшлээс шалтгаалах өвчний групптэй хүмүүс, хүүхэд асрах чөлөөтэй байгаа эхчүүдэд адил хамаарна/ гэж заасан бөгөөд Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “”хамтын гэрээ” гэж тухайн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөр эрхлэх, түүнтэй холбогдох эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөдөлмөрийн хууль тогтоомжоор тогтоосон суурь хэм хэмжээнээс дордуулахгүйгээр харилцан тохиролцож ажилтныг илүү таатай нөхцөлөөр хангах, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, нийгмийн хамгаалалтай холбоотой хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхээр ажил олгогч, ажилтны төлөөлөгчийн хооронд байгуулж, зохих журмын дагуу бүртгүүлсэн тохиролцоог” гэж тодорхойлсон байна. Дээрх урамшууллуудыг олгох эрх зүйн суурь хэм хэмжээ байхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хамтын гэрээг Хөдөлмөрийн тухай хуультай нийцүүлж, өөрчлөлт оруулах.

9. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Борлуулалтын авлагын үлдэгдэл 1,543.4 сая төгрөгөөс найдваргүй авлагын нөөц байгуулаагүй байна. Энэ нь НБББББ-т найдваргүй авлагын нөөцийг байгуулахдаа “авлагын насжилтын тайланд суурилан найдваргүй авлага хасагдуулгын нөөц байгуулна” гэснийг баримтлан ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалтын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагын насжилтыг бодитоор тооцон, найдваргүй авлагын нөөц байгуулан бүртгэл, тайланд тусгах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. гэж заасны дагуу ирүүлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дулааны цахилгаан станц-3 ТӨХК-ийн 55 жилийн ойг тохиолдуулан спортын тэмцээнд оролцоход томилолтын зардал гаргасан.	1	2,916.20	1	2,916.20								
Улаанбаатар хот руу ачаа тээвэрлэх зардалд 630.0 мянган төгрөг зарцуулсан нь анхан шатны баримтаар нотлогдоогүй.	1	630.00	1	630.00								
Саяхилгын шийтгэлтэй байх хугацаанд үр дүнгийн урамшуулал олгосон	1	5,103.00	1	5,103.00								
ТУЗ-ийн тогтоолыг зөрчиж, цалинг илүү тогтоож, олгосон	1	880.70	1	880.70								
Худалдах, худалдан авах гэрээг зөрчиж, алдангийг дутуу бодсон	1	5,227.00	1	5,227.00								
Албан хаагчдын хувийн хэрэглээнд зориулж шатахуун олгосон.	1	4,956.40	1	4,956.40								
Хэвлэлийн захиалга хөрөнгө зарцуулсан	1	792.00	1	792.00								
Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын чиг үүргийг давхардуулан гүйцэтгүүлж, цалингийн зардал гаргасан	1	971.10			1	971.10						
Төсөвт батлагдаагүй халаалтын улирлын хөнгөлөлтийн зардал гаргасан	1	126,600.00			1	126,600.00						
Санхүүгийн тайланд тусгагдсан татварын өр төлбөрүүд Татварын ерөнхий газраас авсан лавлагааны дүнгээс зөрүүтэй.	1	897,828.77			1	897,828.77						
Бараа материал дансанд бүртгэлтэй малыг мах болгон бэлтгэхдээ махны бодит жинг гаргаж бараа материалд бүртгээгүй хариуцсан албан хаагчийн нэр дээр авлага бүртгэсэн.	1	22,851.00			1	22,851.00						
Худалдах, худалдан авах гэрээнд заасан гэрээ сунгах нөхцөл бүрдээгүй байхад гэрээг сунгасан	1	297,393.16			1	297,393.16						
Хувьцаа эзэмшигчдийн хурлаас дотоод аудиторыг ТУЗ-ын дэргэд ажиллуулах зохицуулалт хийснийг хэрэгжүүлэхдээ Дотоод хяналтын албыг татан буулгаж, дотоод хяналтын ажилтныг чөлөөлж, тэтгэмж олгосон.	1	106,948.95			1	106,948.95						

**“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан**

Албан томилолтын хуудасгүй томилолтын зардал гаргасан.	1	13,780.70			1	13,780.70							
Тухайн жилийн төсөвт тусгагдаагүй урамшууллын зардал гаргасан.	1	5,953.20					1	5,953.20					
2022 оны тайлангаар гарсан алдагдлыг баталгаажуулаагүй нь тайлант оны татвар ногдох орлогыг бууруулах боломжийг алдсан.	1	207,100.00					1	207,100.00					
Худалдах, худалдан авах гэрээг сунгахдаа гэрээнд заасан гэрээг сунгах нөхцөлийг баримтлаагүй	1	33,937.88					1	33,937.88					
Төндөр шалгаруулалт бүрийн хавтаст хэргийг бүрдүүлэхдээ нийлүүлэгч байгууллагаас ирсэн бичиг, Сангийн яамнаас ирсэн бичиг зэрэг хуульд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлээгүй	1	-					1	-					
Дуусаагүй барилга дансанд нөөц бараа материалыг бүртгэсэн, НБББББ-г тууштай мөрдөөгүй	1	1,994,829.14					1	1,994,829.14					
Нөөцлөх шаардлагагүй бичиг хэргийн материал, сэлбэг хэрэгслийг их хэмжээгээр нөөцөлсөн.	1	-					1	-					
Дансны авлагаас найдваргүй авлагын нөөц үүсгээгүй	1	46,301.17					1	46,301.17					
Дотоод аудитын нэгжийг томилоогүй.	1	-					1	-					
Хамтын гэрээнд өөрчлөлт оруулах зөвлөмж	1	-					1	-					
Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно. заасны дагуу хариуцлага тооцуулах албан шаардлага өгөх	1	1.00						1		1			
Худалдан авах ажиллагаатай холбоотой ашиг сонирхлын зөрчилтэй болон гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал илэрснийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх	1	538,074.73									1	538,074.73	
Дүн	25	4,313,076.10	7	20,505.30	7	1,466,373.68	9	2,288,121.39	1		1	1	538,074.73



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 01/ ДОН-2024/03/НА-СТА-ТӨА
73 А1170308.

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын чиг үүргийг давхардуулан гүйцэтгүүлж, 971.1 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2 дахь "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана". Үүнд: 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын чиг үүргийн давхардлыг арилгаж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Д.НАРМАНДАХ

Б.ОДХҮҮ

Б.ОЮУНХЭРЛЭН

011041217



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 02/ ДОН-2024/03/НА-СТА-ТӨА
174 А 1170308

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны төсөвт 2023 оны халаалтын улирлын хөнгөлөлтийг зөвхөн галлагаатай сууцанд амьдардаг албан хаагчид болон ахмад ажилчдад тус бүр 100.0 мянган төгрөг олгохоор нийт 27.1 сая төгрөг баталсан бөгөөд гүйцэтгэлээр бүх албан хаагчдад нийт 79.2 сая төгрөг олгосон. Мөн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй 74.5 сая төгрөгийн халаалтын улирлын хөнгөлөлтийг 2023 онд нөхөж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 43 дугаар зүйлийн 43.5 дахь “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”. Үүнд: 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Д.НАРМАНДАХ

Б.ОДХҮҮ

Б.ОЮУНХЭРЛЭН

011041244



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 03/ДОА-2024/03/НА-СТА-ТӨА
/75 А1170308

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд тусгагдсан татварын өр төлбөрүүдийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, Татварын ерөнхий газраас авсан лавлагааны дүнгээс 897.8 сая төгрөгөөр зөрүүтэй буюу илүү илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана". Үүнд: 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй," гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайланд тусгагдсан татварын өр төлбөрүүдийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Д.НАРМАНДАХ

Б.ОДХҮҮ

Б.ОЮУНХЭРЛЭН

011041241



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 04/ДОА-2024/03/НА-СТА-ТӨА
А1170308

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын дансанд бүртгэлтэй малыг мах болгон бэлтгэхдээ махны бодит жинг гаргаж бараа материалд бүртгээгүй хариуцсан албан хаагчийн нэр дээр авлагаар бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө", 14 дүгээр зүйлийн 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана". Үүнд: 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль, журмын дагуу бүртгэж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.Сэмжидмаа

И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Д.Нармандах

Д.НАРМАНДАХ

АУДИТОР

Б.Одхүү

Б.ОДХҮҮ

АУДИТОР

Б.Оюунхэрлэн

Б.ОЮУНХЭРЛЭН

011041229



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 05/ ДАА-2024/03/НН-СТА-ТӨА
177 А 1170308

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдах, худалдан авах гэрээнд заасан гэрээ сунгах нөхцөл бүрдээгүй байхад гэрээг сунгаж, 297.4 сая төгрөгийн алданги тооцоогүй байна.

Энэ нь Худалдах, худалдан авах гэрээний 6.1-д "нийлүүлэгчийн буруугаас шалтгаалан гэрээний 2.1-т заасан хугацаанаас хоцорвол гэрээний үнийн дүнгийн 0.2 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөх ба", 7.1-д "давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно", 7.2-д "гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана". Үүнд: 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Д.НАРМАНДАХ

Б.ОДХҮҮ

Б.ОЮУНХЭРЛЭН



011041231



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 06/ДОА-2024/03/44-СТА-ТӨА
/78 А1170308.

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас дотоод аудиторыг ТУЗ-ын дэргэд ажиллуулах зохицуулалт хийснийг хэрэгжүүлэхдээ Дотоод хяналтын албыг татан буулгаж, дотоод хяналтын ажилтныг чөлөөлж, төсөвт батлагдаагүй 106.9 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана". Үүнд: 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Д.НАРМАНДАХ

АУДИТОР

Б.ОДХҮҮ

АУДИТОР

Б.ОЮУНХЭРЛЭН

ХТҮ-0037 100001

011041234



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 07/ДОН-2024/03/НА-СТА-ТӨА
199 А/1170308.

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын төслийн ажлаар явсан Эрчим хүчний яамны холбогдох албан тушаалтнуудын гадаад албан томилолтын зардалд 13,780.7 мянган төгрөг олгосон байна. Энэ нь томилох эрх бүхий албан тушаалтны томилсон болон үнэлж хаасан томилолтын үнэмлэхээр нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 дэх "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана". Үүнд: 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гадаад томилолтыг томилох эрх бүхий албан тушаалтнаар үнэлүүлж, баталгаажуулах, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг засаж, давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Шууд
Н.Сэмжидмаа
Д.Нармандах
Б.Одхүү
Б.Оюунхэрлэн

И.СЭМЖИДМАА
Д.НАРМАНДАХ
Б.ОДХҮҮ
Б.ОЮУНХЭРЛЭН

11774186
ХТҮ 4257 5139291

011041239



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 08/80 дорнод-2024/03/НА-СААДЛА
00160305

Чойбалсан хот

Г Сахилгын хариуцлага тооцуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Өмнөх аудитаар өгсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх зөвлөмжийг биелүүлэн ажиллаагүй хэрэгжилт 0 хувь, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт хийх зөвлөмжийн биелэлт баримт бичгийг боловсруулах шатандаа буюу 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

2. “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь 2023 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар **Сөрөг** дүгнэлт авсан.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, ..., санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, ... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

“Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга О.Хуягцогт-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

011041214

011050315



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 02/24 ДДА-2024/03/НА-СТ-ТӨА
АН 60305

Чойбалсан хот

Г

Төлбөр барагдуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хэвлэлийн захиалгад 792.0 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.3 дэх “хэвлэлийн захиалгын төлбөр” гэснийг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-т “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хэвлэл захиалгад зарцуулсан 792,000.00 /Долоон зуун ерэн хоёр мянга/ төгрөгийг Төрийн сан банкин дахь хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Д.НАРМАНДАХ



011050318



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 03/25 ДОН-2024/03/НА-СА-ТӨА Чойбалсан хот
А1160305

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын удирдлагын хувийн хэрэглээнд зориулж 4,956.4 мянган төгрөгийн шатахуун олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.1-д “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно”, 6.2-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.6-т “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Удирдлагын хувийн хэрэглээнд зарцуулсан 4,956,399.00 /дөрвөн сая есөн зуун тавин зургаан мянга гурван зуун ерэн найман/ төгрөгийг Төрийн сан банкин дахь хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА
АХЛАХ АУДИТОР  Д.НАРМАНДАХ

ХТ-17144078
ХТ-17144078

011050321



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 04/26 ддн 2024/03/17-сая-тба
А1160305

Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улаанбаатар хот руу ачаа тээвэрлэх зардалд 630.0 мянган төгрөг зарцуулсан нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-т “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй зарцуулсан 630,000.00 /зургаан зуун гучин мянга/ төгрөгийг Төрийн сан банкин дахь хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Д.НАРМАНДАХ



011050324



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 05/24 ДДН-2024/02/ТА-СН-ТН Чойбалсан хот
Н 0160205

Г

Төлбөр барагдуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захиралд сахилгын шийтгэлтэй байх хугацаанд 5,103.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гүйцэтгэх захиралтай 2022 оны 05 дугаар 26-ны өдөр байгуулсан “онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-ний 4.4-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн гүйцэтгэх захирлын сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй тохиолдолд сарын болон жилийн үр дүнгийн нэмэгдэл болон урамшуулал олгохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үр дүнгийн урамшуулалд олгосон 5,103,000.00 /Таван сая нэг зуун гурван мянга/ төгрөгийг Төрийн сан банкин дахь хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт хариуцуулав


ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Д.НАРМАНДАХ



011050329



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 06/28 2024-0024/03/НА-СГА-ТӨА
А1160505

Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зарим албан хаагчдын цалинг 23.8-аас 28.9 хувиар нэмэгдүүлж 880.7 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна. Энэ нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн албан хаагчдын цалинг 20 хувиар нэмэгдүүлсэн 2023.11.13-ны өдрийн 23 дугаар тогтоол, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-д “Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна”, 83.6-д “Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Цалинд олгосон 880,698.00 /найман зуун наян мянга зургаан зуун ерэн найман/ төгрөгийг Төрийн сан банкин дахь хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

И.СЭМЖИДМАА

Д.НАРМАНДАХ



011050336



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 07/29 ДДА-2024/03 /НА САА-ТӨА
АМ60305

Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдах, худалдан авах гэрээнд заасан хугацааг хэтрүүлж нийлүүлсэн 2 аж ахуйн нэгжийн алдангийг 1,866.6 сая төгрөгөөр дутуу тооцоолсон, гэрээ сунгах хүсэлт ирүүлээгүй Аж ахуй нэгжийн гэрээг сунгаж 3,360.4 мянган төгрөгийн алданги тооцоогүй байна. Энэ нь худалдах, худалдан авах гэрээний 6.1-д “нийлүүлэгчийн буруугаас шалтгаалан гэрээний 2.1-т заасан хугацаанаас хоцорвол гэрээний үнийн дүнгийн 0.2 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөх ба ...”, 7.1-д “давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно”, 7.2-д “гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-г “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Гэрээний дагуу алданги тооцоогүй 5,227,010.00 /таван сая хоёр зуун хорин долоон мянга арван/ төгрөгийг Төрийн сан банкин дахь хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

011050331

2. Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод Бүсийн Эрчим Хүчний Систем" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

АХЛАХ АУДИТОР  Д.НАРМАНДАХ

2117144066
ХТҮ4037 9000091